



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/31

Хажуу шинэ ус


Сумын Аварга саальчин цол олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь заалт, 66 зугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сумын Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 2025 оны 02 дүгээр сарын 19-ний өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Мал сүргийнхээ ашиг шимийг нэмэгдүүлж сүү цагаан идээгээ бэлтгэх уламжлалт аргыг эзэмшин аймаг, сумын үзэсгэлэн худалдаанд тогтмол оролцож, өрхийн эдийн засагтаа өндөр хувь нэмэр оруулан мал аж ахуйн салбарт тогтвор суурьшилтай ажиллан бусдыг хошуучлан манлайлж буй Ажирхай багийн малчин А.Шинэбаяр, Морьт багийн малчин Г.Алтанчимэг, Хонгор багийн малчин Д.Баяржаргал нарт "Сумын аварга саальчин" цол олгосугай.

2. Сумын аварга саальчин өрхөөр шалгарсан малчин өрхөд хүндэтгэл үзүүлэх, цол энгэрийн тэмдэг гардуулах арга хэмжээ зохион байгуулах, шаардагдах төсвийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны дарга (Н.Ганбат)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавиж, хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Б.ДОРЖСҮМБЭР

482501081

[illegible][illegible]

482501081